

| NSW муж улсын боловсролын яам

## HSC бичгийн шалгалтын явцад COVID-19 safe журмыг баримтлах нь

Энэхүү мэдээлэл нь сурагчид HSC шалгалтын үеэр COVID-19 safe журмыг хэрхэн баримтлах талаарх мэдээллийг сурагчдад олгох зорилготой. Сурагчид, сургуулийн багш ажилчдын аюулгүй, сайн сайхан байдал нь бидний хувьд маш чухал бөгөөд тийм учраас энэхүү журмыг баримтлахыг бид бүх сурагчдаас хүсч байна.

### Өвчний шинж тэмдэг буйг хянах үзлэг

- Хэрэв биеийн байдал тааруу бол тухайн сурагч шалгалтанд ирэх ёсгүй.
- Шалгалт өгөхөөр ирэх сурагчдаас, томуу-тест өвчний шинж тэмдэг илэрч буй, мөн NSW Health-ийн тушаалын дагуу өөрийгөө тусгаарлах ёстой байгаа эсэхийг асуух болно.
- Томуу-тест өвчний шинж тэмдэг бүхий, эсвэл бие тааруу байгаа сурагчдыг сургуулиас явахыг хүсэх бөгөөд COVID-19-ын шинжилгээнд хамрагдахыг хүсэх болно.
- COVID-19-тэй ижил шинж тэмдэг бүхий өвчнөөр өвчилсөн, эсвэл энэхүү өвчнөөр өвдөж байсан сурагчид одооноос өөрийн эмч (GP)-тэйгээ зөвлөлдөн шалгалт өгөх эсэх талаар төлөвлөх хэрэгтэй. Таны эмч (GP) албан тодорхойлолт хийж энэхүү өвчний шинж тэмдэг нь сурагчид жирийн үед ч илэрч байдаг гэх мэтээр тодорхойлж бичнэ.

### Томуу-тест өвчний илрэх шинж байдал

Томуу-тест өвчин дараах шинж тэмдгүүдээр илэрнэ: халуурах, ханиах, хоолой хөндүүрлэх, амьсгал давчдах, амт болон үнэр мэдрэхгүй байх. COVID-19-ын шинж тэмдгийн талаарх нэмэлт мэдээлэл [NSW Health website](#) –д нийтлэгдсэн байгаа болно.

Томуу-тест өвчний ялимгүй боловч шинж тэмдэг илэрч байгаа сурагчид сургуулиас шууд явах хэрэгтэй бөгөөд COVID-19-ын шинжилгээнд хамрагдан сөрөг хариу авч уг өвчний шинж тэмдэггүй болсны дараа л сургууль дээр ирэхийг зөвшөөрнө.

### COVID-19-ын шинжилгээнд түргэвчилсэн байдлаар хамрагдах

HSC шалгалт өгөх сурагчид COVID-19-ын шинжилгээнд түргэвчилсэн байдлаар хамрагдах боломжтой.

Ингэхийн тулд сурагч доорх алхамуудыг хийх ёстой:

- Шинжилгээ өгөхдөө өөрийгөө HSC шалгалт өгөх сурагч гэдгээ хэлэх
- Шинжилгээ авч буй эмч сувилагчаар өөрийн шинжилгээний бичгэн дээр “HSC - яаралтай” гэж тэмдэглүүлэх
- Шинжилгээний сөрөг хариу гартал өөрийгөө тусгаарлах
- Сургуульдаа сөрөг гарсан шинжилгээний хариу үзүүлэх
- 36 цагийн дотор хариугаа аваагүй бол эмнэлэгтэй өгсөн утасны дугаараар холбогдох.

## Өвчин халдаах эрсдлийг багасгах

- Шалгалт эхлэхээс өмнө сурагчид гараа угаах буюу гар ариутгагчаар цэвэрлэвэл зохино.
- Шалгалтын үед хувийн ариун цэврийг сайтар сахих. Үүнд: ханиах буюу найтаахдаа цаасан алчуур буюу гарын тохойгоор амаа хаах, хэрэглэсэн цаасан алчуурыг шалгалтын дараа хогийн саванд хийх
- Шалгалтын өдөр бусадтай гар барих, тэврэлцэхээс зайлсхийх
- Шалгалт явагдах бүх анги танхимууд дараах ариун цэврийн хэрэгслээр хангагдсан байх болно:
  - Гар ариутгагч
  - Нойтон нэг удаагийн алчуурууд
- Хэрэв хүсвэл сурагч шалгалт өгөхөөр суух ширээгээ шалгалтын өмнө арчиж цэвэрлэж болно.
- Шалгалтын өмнө буюу хойно сурагчид олноор бөөгнөрөхгүй байх
- Шалгалтын өрөөг өдөр бүр цэвэрлэж байх болно

## Шалгалтанд ирэх болон бүртгүүлэх

- Сурагчид шалгалт эхлэхээс 20 минутаас ихгүй хугацааны өмнө ирэн шалгалт явагдах танхимд бүртгүүлэх ба өвчний шинж тэмдэг буй эсэхээ шалгуулна.
- Түүний дараа сурагчид бүртгэлийн дэвтэрт гарын үсгээ зурах ба мөн өөрийн хаяг, холбогдох дугаараа үлдээн өвчний шинж тэмдэг байхгүй гэдгээ баталгаажуулна.

## Шалгалтын байр солигдох

Шалгалт явагдахаар товлосон байранд шалгалт явагдах боломжгүй болсон тохиолдолд шалгалтыг явуулах нөөц байрыг сургуулиуд бэлтгэсэн байгаа болно. Шалгалтын байр гэнэт солигдсон тохиолдолд сурагч хаана очихоо мэдэж байхад туслах зорилгоор энэ мэдээллийг таны шалгалтын хуваарь бүхий хуудсан дээр бичсэн байгаа болно.

Сурагч нь шалгалтын нөөц байранд зөвхөн сургууль мэдэгдсэн тохиолдолд очих ёстой. Сургууль танд энэ талаар мэдэгдээгүй л бол та тийш очих ёсгүй.

## COVID-19-ийн дэгдэлт тархсан нь батлагдсан тохиолдол

Хэрэв шалгалтын үеэр NSW Health тухайн сургуулийг COVID-19-ын дэгдэлт гарсан сургууль гэж тогтоовол үүнээс улбаалан гарах сөрөг нөлөөг аль болон багасгах зорилгоор шаардлагатай арга хэмжээнүүдийг авсан болно. Шалгалтын өмнөх өдөр сургууль танд таны шалгалтын хуваарьт бичигдсэн ёсоор шалгалт нөөцийн байранд болох талаар, эсвэл шалгалт цуцлагдсан талаар мэдээлж магадгүй юм.

## Өвчний болон бусад шалтгаан

Өвчний шинж тэмдэгтэйгээс шалгалтанд орох боломжгүй болсон, эсвэл шалгалтын өдөр өвчний шинж тэмдэгтэйгээс шалгалт өгч чадаагүй сурагчид шалгалт өгсөнд тооцуулахаар өвчний буюу бусад шалтгааны улмаас гэсэн үндэслэлээр өргөдөл гаргах эрхтэй. Шаардлагатай бол таны сургууль энэ тал дээр таньд туслалцаа үзүүлэх болно.

## Утсан Орчуулгын Үйлчилгээ

Хэрвээ та дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл сургуулийн захирал руу залгаарай. Хэрвээ танд орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний Төвтэй 131 450 дугаараар холбогдон өөрийн хэлний орчуулагчтай холбож өгөхийг хүсээрэй. Энэхүү үйлчилгээ нь үнэ төлбөргүй болно.